

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/84/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn Аудитын менежер: Д.Нар-Од Утас: 99091993 Цахим хаяг: narod.d@solidunity.mn Аудитор: Д.Нар-Од Утас: 99091993 Цахим хаяг: narod.d@solidunity.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.Хараат бус аудитын дүгнэлт	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
3. Аудитын илрүүлэлт	10
3.1 Зөвлөмж	10
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УБЦТС	Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 665
танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИЛЧ
ОРД ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ГАНТУЛГА ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 стратеги зорилгын 13

зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 98.4 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	32,061,768.05	41,837,006.69
1.1.02	Дансны авлага	52,878,474.68	30,106,947.30
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,152,681.08	1,152,681.08
1.1.04	Бусад авлага	785,979.32	2,456,663.42
1.1.06	Бараа материал	101,492,675.70	49,705,702.53
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,919,131.00	2,331,432.71
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	191,290,709.83	127,590,433.73
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,217,657,599.68	2,974,787,266.07
1.2.02	Биет бус хөрөнгө	215,137,933.27	214,237,933.27
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,432,795,532.95	3,189,025,199.34
1.3	Нийт хөрөнгийн дүн	3,624,086,242.78	3,316,615,633.07
2.1.1.01	Дансны өглөг	-	210,266.13
2.1.1.02	Цалингийн өглөг	-	190,605.00
2.1.1.03	Татварын өр	26,416,239.35	17,182,829.70
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	319,302.50	2,984,199.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,735,541.85	20,567,899.83
2.2	Өр төлбөрийн нийт дүн	26,735,541.85	20,567,899.83
2.3.01	Өмч: - төрийн	3,665,904,113.50	60,738,200.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	795,767,499.30	795,767,499.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	210,609,600.00	210,609,600.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,074,930,511.87)	2,228,932,433.94
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг (алдагдал)	-	(301,302,967.69)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг (алдагдал)	(1,074,930,511.87)	2,530,235,401.63
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,597,350,700.93	3,296,047,733.24
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	3,624,086,242.78	3,316,615,633.07

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,249,880,310.59	1,464,707,648.49
02	Борлуулалтын өртөг	1,218,209,341.88	1,692,716,976.19
03	Нийт ашиг (алдагдал)	31,670,968.71	(228,009,327.70)
05	Хүүний орлого	-	130,608.91
08	Бусад орлого	58,320,000.45	217,355,851.99
08.1	Орлогын дүн	58,320,000.45	217,486,460.90
10	Ерөнхий ба удирдлагын зардал	275,491,064.92	274,666,234.91
12	Бусад зардал	36,364,751.77	16,100,000.00
12.1	Зардлын дүн	311,855,816.69	290,766,234.91
17.1	Олз, гарзын дүн	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(221,864,847.53)	(301,289,101.71)
19	Орлогын татварын зардал	-	13,865.98
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(221,864,847.53)	(301,302,967.69)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(221,864,847.53)	(301,302,967.69)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(221,864,847.53)	(301,302,967.69)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,425,525,742.81	647,532,654.66	16,480,800.00	(857,618,950.78)	2,231,920,246.69
02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	4,553,286.44	4,553,286.44
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(221,864,847.53)	(221,864,847.53)
06	Өмчид гарсан өөрчлөлт	1,240,378,370.69	-	194,128,800.00	-	1,434,507,170.69
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	148,234,844.64	-	-	148,234,844.64
09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,665,904,113.50	795,767,499.30	210,609,600.00	(1,074,930,511.87)	3,597,350,700.93
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	3,605,165,913.50	3,605,165,913.50
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(301,302,967.69)	(301,302,967.69)
14	Өмчид гарсан өөрчлөлт	(3,605,165,913.50)	-	-	-	(3,605,165,913.50)
17	2023 оны 12-р сарын 31-р нээрх үлдэгдэл	60,738,200.00	795,767,499.30	210,609,600.00	2,228,932,433.94	3,296,047,733.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,465,041,320.56	1,781,378,240.48
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	694,794,294.24	660,921,753.52
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	138,659.79
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	710,323,100.00	941,400,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	59,923,926.32	178,917,827.17
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,608,508,921.89	1,761,448,096.84
1.2.1	Ажиллагчдад төлсөн	636,654,404.32	692,336,073.28
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	183,751,770.28	198,313,787.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	176,545,016.80	181,384,517.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	170,169,109.24	180,606,693.82
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	318,637,739.40	361,083,944.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	83,947,301.79	129,943,771.65
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	377,535.00	370,335.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	38,426,045.06	17,408,975.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(143,467,601.33)	19,930,143.64
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	32,044,900.00	10,154,905.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	32,044,900.00	10,154,905.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,044,900.00)	(10,154,905.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(175,512,501.33)	9,775,238.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	207,574,269.38	32,061,768.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,061,768.05	41,837,006.69

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны	2023 оны		2023 оны	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт (хэмнэлт)	
1	Санхүүжилтийн орлого	645,748,272.74	855,818,181.82	855,818,181.80	0.02	0%
2	Дулаан борлуулсны орлого	575,362,737.85	557,186,880.00	573,585,866.69	16,398,986.69	2.9%
3	Хэрэглээний халуун усны орлого	28,769,300.00	20,958,156.00	35,303,600.00	14,345,444.00	68.4%
4	Бусад орлого	58,320,000.45	25,000,000.00	160,486,460.90	135,486,460.90	541.9%
Нийт дүн		1,308,200,311.04	1,458,963,217.82	1,625,194,109.39	166,230,891.61	11.4%
1	Үндсэн болон нэмэгдэл цалин	695,868,200.00	723,036,000.00	760,797,915.04	(37,761,915.04)	(5.2)%
2	ЭМНДШ-ийн зардал	102,691,426.48	104,117,184.00	111,638,774.58	(7,521,590.58)	(7.2)%
3	Цахилгааны төлбөр	72,909,514.50	118,770,032.85	115,022,941.80	3,747,091.05	3.2%
4	Түлш халаалтын зардал	228,751,168.09	390,794,250.00	291,006,751.91	99,787,498.09	25.5%
5	Цэвэр бохир усны төлбөр	49,434,594.54	48,717,450.00	56,802,574.55	(8,085,124.55)	(16.6)%
6	Тээврийн зардал	16,458,600.00	18,728,000.00	20,985,700.00	(2,257,700.00)	(12.1)%
7	Шуудан холбооны зардал	2,342,064.56	2,422,800.00	2,990,808.13	(568,008.13)	(23.4)%
8	Урсгал засвар	75,747,916.12	43,086,200.00	71,626,192.30	(28,539,992.30)	(66.2)%
9	Шатахууны зардал	53,176,262.64	55,731,630.00	56,336,551.40	(604,921.40)	(1.1)%
10	Хөдөлмөр хамгааллын зардал	24,038,070.67	33,227,000.00	73,650,324.93	(40,423,324.93)	(121.7)%
11	Бичиг хэргийн зардал	6,804,389.86	2,384,800.00	4,661,886.31	(2,277,086.31)	(95.5)%
12	Нэг удаагийн буцалтгүй тусламж	6,134,500.00	4,500,000.00	16,100,000.00	(11,600,000.00)	(257.8)%
13	Элэгдлийн зардал	131,287,493.13	184,252,632.00	353,871,429.06	(169,618,797.06)	(92.1)%
14	Үйлчилгээний хөлс	4,090,909.09	5,931,112.64	5,708,400.00	222,712.64	3.8%
15	Газрын төлбөр	2,072,982.00	1,897,296.00	1,873,296.00	24,000.00	1.3%
16	Авто машины даатгалын зардал	370,035.00	370,035.00	302,112.29	67,922.71	18.4%
17	Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,589,711.03	8,590,575.04	8,590,575.06	(0.02)	0.0%
18	Авто тээврийн хэрэгслийн татвар	2,338,904.00	671,904.00	281,735.00	390,169.00	58.1%
29	Усны албан татварын зардал	442,669.92	2,200,047.70	2,272,028.00	(71,980.30)	(3.3)%

20	Зам ашигласны төлбөр	850,000.00	390,000.00	220,000.00	170,000.00	43.6%
21	Агаарын бохирдлын төлбөр	239,175.00	57,000.00	26,400.00	30,600.00	53.7%
22	Авто тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөр	110,000.00	253,000.00	253,000.00	-	0.0%
23	Хог хураамж	609,780.00	609,700.00	777,205.00	(167,505.00)	(27.5)%
24	Вагон таталт тавилтын зардал	3,789,400.00	3,980,000.00	3,492,100.00	487,900.00	12.3%
25	Үйл ажиллагааны бус зардал	31,230,600.00	-	-	-	0.0%
26	Үйл ажиллагааны бус орлого	-	-	57,000,000.00	57,000,000.00	100%
27	Бусад зардал	9,686,791.94	6,520,000.00	24,208,375.72	(17,690,375.72)	(271.3)%
Нийт дүн		1,530,065,158.57	1,761,238,649.23	1,926,497,077.08	(165,260,427.85)	(9.4)%
1	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(221,864,847.53)	(302,275,431.41)	(301,302,967.69)	972,463.72	(0.3)%
2	Татварын зардал	-	-	-	-	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(221,864,847.53)	(302,275,431.41)	(301,302,967.69)	972,463.72	(0.3)%
4	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	1.0	1.2	1.2	-	-
5	Авлага	54,817,135.08	27,408,500.00	33,716,291.80	(6,307,791.80)	(23.0)%
6	Өглөг	26,735,541.85	18,260,100.00	20,567,899.83	(2,307,799.83)	(12.6)%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,178.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тайлант хугацаанд өмчийн дансанд бүртгэсэн өмнөх үеийн үр дүнг залруулан бүртгэхдээ 60,677.5 мянган төгрөгийн зөрүүтэй дүнгээр бүртгэсэн нь Санхүүгийн тайлагналын Онолын үзэл баримтлал 7.7 болон 7.8 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасан зарчимтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй;
- Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацааг санхүүгийн программд алдаатай оруулсантай холбоотой элэгдлийг зардлыг 2,375.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон нь НББОУС-16 Үндсэн хөрөнгө 50 болон 55-р праграф, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасан зарчимтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй;
- Бусад орлогод 107.7 мянган төгрөгийн хүүгийн орлогыг бүртгэсэн нь Санхүүгийн тайлагналын Онолын үзэл баримтлал 7.7 болон 7.8 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасан зарчимтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй;
- Халаалтын орлогод 852.0 мянган төгрөгийн халуун усны хэрэглээний орлогыг бүртгэсэн нь Санхүүгийн тайлагналын Онолын үзэл баримтлал 7.7 болон 7.8 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасан зарчимтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй;
- Даатгалын зардлыг мөнгөн сууриар бүртгэж 166.2 мянган төгрөгийн урьдчилж төлсөн даатгалын зардлыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь Санхүүгийн тайлагналын Онолын үзэл баримтлал 7.7 болон 7.8 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасан зарчимтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй;

Аудитаар нийт 1,300.4 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 2 ширхэг барилга байгууламж, 2 ширхэг машин, тоног төхөөрөмж, 1 ширхэг тээврийн хэрэгсэл, 11 ширхэг тавилга, эд хогшил, 2 ширхэг компьютер

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дагалдах хэрэгслийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй байгаа нь НББОУС-16 Үндсэн хөрөнгө 56-57-р заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, холбогдох стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Айл өрхийн халаалтын орлогоос үүссэн Хангай СӨХ-өөс авах 1,300.4 мянган төгрөгийн 10-аас дээш жилийн насжилттай авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагын насжилтын судалгааг гаргаж, авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах, хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянах дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацаанд өмчийн дансанд бүртгэсэн өмнөх үеийн үр дүнг залруулан бүртгэхдээ зөрүүтэй дүнгээр бүртгэсэн.	1	60,677.5	-	-	1	60,677.5	1	60,677.5	-	-	-	-
Тээврийн хэрэгслийн элэгдлийг дутуу тооцоолсон.	1	2,375.0	1	2,375.0	-	-	1	2,375.0	-	-	-	-
Бусад орлогод хүүгийн орлогыг бүртгэсэн.	1	107.7	-	-	1	107.7	1	107.7	-	-	-	-
Халаалтын орлогод халуун усны хэрэглээний орлогыг бүртгэсэн	1	852.0	-	-	1	852.0	1	852.0	-	-	-	-
Даатгалын зардлыг мөнгөн сууриар бүртгэсэн.	1	166.2	1	166.2	-	-	1	166.2	-	-	-	-
Дүн	5	64,178.4	2	2,541.2	3	61,637.2	5	64,178.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Айл өрхийн халаалтын орлогоос үүссэн Хангай СӨХ-тэй холбоотой авлага 10-аас дээш жилийн насжилттай байна. Уг авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй.	1	1,300.4	-	-	-	-	1	1,300.4	-	-	-	-
Дүн	2	1,300.4	-	-	-	-	2	1,300.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны хуулийн дагуу 3 мэдээллийг ил тод байршуулаагүй, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	302,970.3	1	302,970.3	-	-
Дүн	1	302,970.3	1	302,970.3	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Татварын цахим төлбөрийн баримтын системд орлогын баримтыг зөрүүтэй оруулсантай холбоотой татварын тодорхойлолтоор илэрхийлэгдсэн НӨАТ-ын өглөг нь байгууллагын бүртгэлд тусгасан НӨАТ-ын өглөгийн дүнгээс .зөрсөн	1	23,995.4	-	-	1	23,995.4
Дүн	1	23,995.4	-	-	1	23,995.4
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой						
Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж буй Toyota Villfire маркийн УЕН 22-84 улсын дугаар бүхий тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цэнхэр дугаараар солиогүй	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-
Нийт дүн	3	326,965.7	1	302,970.3	2	23,995.4